

ДОТООДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ



2025.08.25

Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Хаан банкны хувьцаа тогтвортой өсөлтийг үзүүлэн арилжаалагдаж байна.
- Сүү ХК 17% хүүтэй бонд гаргахаар боллоо
- Шунхлай ХХК 50 тэрбум төгрөгийн бонд гаргана
- Эхний хагас жилд МУ-ын ДНБ 5.6% өслөө
- TSX:ERD зорилтот ханш 1.30

МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	-0.85%	-0.71%	25.47%
MSE A	-0.52%	-1.21%	20.27%
MSE B	0.6%	-0.21%	34.89%

2025/08/18 – 2025/08/22

Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
KHAN	244,010,938.00
MGLA	231,620,642.18
MSE	148,419,603.48
APU	103,733,592.37
GLMT	83,454,328.00

2025/08/18 – 2025/08/22

Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
HSG	11,960.00	32.15%
UYN	1,666.00	16.91%
SHV	2,875.00	15.00%
HGN	61.50	14.85%
JTB	50.00	10.86%

2025/08/18 – 2025/08/22

2025 он 08-р сарын 25

Зах зээлийн
үнэлгээ тэрбум ₮

12,319

ТОП-20 индекс

48,589

MSE A

18,084

MSE B

14,458

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

5.6%

2025 - II улирал

Инфляц

8.1%

2025-07 сар

ГВУН(сая\$)

5,379.75

2025-07 сар

Бодлогын

хүү

12.0%

ЗГ-ын бондын

өгөөж

6.6%


USD/MNT

3,594.29

2025-08-24

 **Эдийн засгийн мэдээлэл****ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ДНБ 5.6% ӨСЛӨӨ**

График 1. Монгол улсын ДНБ өсөлт (2015 оны зэрэгцүүлэх үнээр)



Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр, Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) үйлдвэрлэлийн аргаар тооцсоноор 2025 оны эхний хагас жилд 40.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.3 их наяд төгрөгөөр буюу 8.8%-иар өссөн байна. Харин ДНБ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2025 оны эхний хагас жилд 5.6 хувиар өссөн. Эдийн засгийн өсөлтөд хамгийн их нөлөөлсөн нь хөдөө аж ахуйн салбар бөгөөд нэмэгдэл өртөг нь 1.5 их наяд төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 43.5%-ийн өсөлт үзүүлжээ. Энэ нь нийт өсөлтийн 3.6 нэгж хувийг дангаар бүрдүүлсэн байна.

Мөн үйлчилгээний салбар ч өсөлтөд хүчтэй нөлөөлсөн бөгөөд 1.9 их наяд төгрөгөөр нэмэгдэж, 12.2%-ийн өсөлт гаргасан нь нийт өсөлтөд 0.7 нэгж хувийг оруулжээ.

Үүнээс гадна:

- Уул уурхай, олборлолтын салбарын өсөлт: 0.1 нэгж хувь
- Үйлдвэрлэл, барилгын салбар: 1.0 нэгж хувь
- Бүтээгдэхүүний цэвэр татвар: 0.2 нэгж хувь

Гадаад худалдаа, цэвэр экспортын алдагдал

Хэдийгээр дотоодын үйлдвэрлэл өссөн ч гадаад худалдааны тэнцэл алдагдалтай гарсан байна. Экспорт 9.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 427.3 тэрбум төгрөгөөр (4.5%) буурсан. Импорт 16.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 234.6 тэрбум төгрөгөөр (1.5%) өссөн. Ингэснээр 2025 оны эхний хагас жилд бараа, үйлчилгээний цэвэр экспорт 7.2 их наяд төгрөгийн алдагдалтай гарчээ.

СҮҮ ХК 17% ХҮҮТЭЙ БОНД ГАРГАНА

Сүү ХК энэ сарын эхээр хөрөнгийн зах зээлд шинэ бонд гаргах зөвшөөрлөө СЗХ-ноос авч, Улаанбаатар Үнэт Цаасны Бирж дээр арилжаалж эхлэхээр болсон байна. Энэ удаагийн бондын хэмжээ 5 тэрбум төгрөг, хугацаа нь нэг жил, жилийн хүү нь 17%-тай байх аж.

Энэ бол Сүү ХК-ын хоёр дахь удаагийн бондын гаргалт юм. Өмнөх удаагийн гаргалт нь 2017 онд хийгдэж, тухайн үед компани 6 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулагчдаас босгож байжээ.


Улаанбаатар ҮЦБирж дээрх арилжаа нь хөрөнгийн зах зээлд бондын арилжаа идэвхжих, жижиг дунд хөрөнгө оруулагчдын оролцоо нэмэгдэх боломжийг нээж байна.



Зах зээлийн мэдээлэл

ХААН БАНКНЫ ХУВЬЦАА ХАМГИЙН ИДЭХТЭЙ АРИЛЖААЛАГДАЖ БАЙНА

График 2. Хаан банк ХК-ний ханш



Хаан банкны хувьцааны ханш тогтвортой өсөлтийг үзүүлэн идэхтэй арилжаалагдаж байна. Долоо хоногын турш 244 сая төгрөгийн арилжааны идэхтэй байв. Мөн Хаан банкны үнэ ашгийн харьцаа 3.07 байгаа ба, P/B харьцаа 0.9 байна. Үүнээс харахад хэдий хувьцааны ханш өсөж яваа ч гэсэн харьцаа үзүүлэлтүүд бага хэвээр байсаар байгаа ба худалдан авахад тохиромжтой байна.

TSX:ERD ХУВЬЦААНЫ ХАНШИЙН ҮЗҮҮЛЭЛТ




ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн хэлбэлзэл (2015-2025)

	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	ДУНДАЖ
1 сар	-2.10%	-1.00%	5.40%	-4.20%	7.50%	0.90%	10.50%	1.90%	3.50%	7.00%	2.90%	2.90%
2 сар	-3.50%	-3.00%	-0.90%	-0.10%	-0.60%	-0.90%	29.20%	-4.60%	2.40%	5.50%	1.70%	2.30%
3 сар	-3.50%	-5.10%	4.60%	-1.00%	-2.60%	-4.00%	31.20%	-6.10%	0.50%	1.90%		1.60%
4 сар	-3.00%	-1.50%	2.50%	-4.60%	-3.70%	-8.70%	4.10%	-0.90%	-5.20%	-3.30%		-2.40%
5 сар	-2.40%	-1.20%	-1.60%	-2.00%	0.30%	-2.10%	1.20%	-6.70%	0.50%	-0.40%		-1.40%
6 сар	13.90%	5.20%	-1.60%	0.90%	-1.80%	-1.00%	-7.70%	-3.70%	-0.60%	0.80%		0.50%
7 сар	-2.60%	10.80%	8.20%	-1.00%	3.60%	2.00%	-1.10%	-0.80%	1.10%	9.80%		3.00%
8 сар	-6.70%	-1.80%	8.70%	-0.90%	-2.80%	1.60%	7.70%	4.60%	0.00%	3.50%		1.40%
9 сар	-0.40%	-7.40%	16.60%	3.50%	-3.20%	2.70%	27.50%	-1.50%	-5.40%	-1.30%		3.10%
10 сар	-0.60%	-2.70%	16.90%	2.10%	-3.60%	1.60%	-10.00%	-1.90%	0.60%	0.20%		0.30%
11 сар	-2.90%	-3.40%	9.30%	-2.00%	0.00%	0.50%	-2.40%	1.10%	4.60%	1.80%		0.70%
12 сар	-3.60%	7.00%	0.10%	0.10%	1.90%	3.30%	5.80%	5.40%	5.00%	2.00%		2.70%

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.